

төлөвлөгөөний биелэлт 164.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Мөн орон нутгийн төсөвт торгууль, шийтгэлийн орлогоор 10895.0 мянган төгрөг, тэмдэгтийн хураамжаар 74109.5 мянган төгрөг, үл хөдлөх борлуулсны орлогоор 555635.8 мянган төгрөг нийт 640640.3 мянган төгрөгийн орлого оруулсан. Тус хэлтсийн төсөв 2019 онд 376,799.8 мянган төгрөгөөр батлагдсан. 11 дүгээр байдлаар 345 827.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, 341 961.4 мянган төгрөгийг зохих зардлуудад төсвийн хуваарийн дагуу зарцуулаад байна. Улсын бүртгэлийн хэлтсийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн иж бүрэн программ ашиглаж олон улсын стандартад нийцүүлэн хөтөлж, байгууллагын мөнгөн хөрөнгийн зарцуулалтанд санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжийн хүрээнд байнгын хяналт тавьж, төсвийн гүйцэтгэлийн болон орлогын сар бүрийн мэдээг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж СТСХэлтэст болон УБЕГ-т хүргүүлсэн.

Сургалтын чиглэлээр:

Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдад сургалт, семинар зохион байгуулах замаар албан хаагчдын мэдлэг чадавхийг дээшлүүлж, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах зорилтын хүрээнд тайлант хугацаанд алба хаагч нарыг дараах сургалтуудад хамруулаад байна.

УБЕГ-аас зохион байгуулсан дараах цахим болон танхимын сургалтад хамрагдсан.

Үүнд:

- 2019 оны 02 дугаар сард Улсын бүртгэлийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд хэлтсийн дарга Ц.Тэгшжаргал,
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим системийн шинэчилсэн хувилбар Eprs2 програмыг орон нутгийн хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбогдуулан зохион байгуулсан цахим сургалтад ЭХЭУБТ-ийн 2 улсын бүртгэгч Г.Батсайхан, Т.Оюунчимэг нар,
- Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас зохион байгуулсан “Бүртгэлийн хууль тогтоомжийг таниулах үйл ажиллагаанд гарч буй алдаа дутагдлыг багасгах, дүрэм, журмыг нэг мөр ойлгох тухай”, “Хуулийн этгээдийн бүртгэл, цахимжуулалтын системийн тухай” цахим сургалт, 10 сард “Хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарын нэгдсэн сургалт”-д Хуулийн этгээдийн улсын бүртгэгч Б.Ариунаа,
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны чиглэлээр цахим сургалтад эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга Т.Оюунчимэг, иргэний бүртгэлийн тасгийн дарга Б.Баттуяа, хяналтын улсын байцаагч Ө.Сонинбаяр,
- Удирдлагын академиас зохион байгуулсан “Бодлогын хэрэгжилтийг үнэлэх арга зүй” сэдэвт сургалтад 2019 оны 05 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд хяналтын улсын байцаагч Ө.Сонинбаяр,
- “Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй төслийн дунд хугацааны үр дүн”, “Иргэний улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал” сургалтад Иргэний бүртгэлийн тасгийн дарга Б.Баттуяа, иргэний улсын бүртгэгч Б.Баясгалан, бичиг хэргийн ажилтан, “Иргэний улсын бүртгэлийн програмын шинэчлэлийн тухай” сургалтад иргэний улсын бүртгэгч Д.Сарантуяа, Г.Нандин-Эрдэнэ нар
- Хяналтын улсын байцаагч нарын сургалтад хяналтын улсын байцаагч Ө.Сонинбаяр
- Мэдээллийн технологийн ажилтны сургалтад ажилтан Г.Ялалт нар тус тус хамрагдсан.
- “Нэг иргэн-нэг бүртгэл” хэлэлцүүлэгт дарга Ц.Тэгшжаргал, иргэний улсын ахлах бүртгэгч Б.Баттуяа нар оролцсон.

Орон нутгаас зохион байгуулсан сургалт семинарт дараах албан хаагчдыг хамруулсан. Үүнд:

- Харилцаа холбооны зохицуулах хорооноос зохион байгуулсан “Шуудангийн нэгдсэн код нэвтрүүлэх тухай” сургалтад бичиг хэргийн ажилтан Н.Цэндмаа
- Дорноговь аймаг 2019 оныг “Гэр бүлийг дэмжих” жил болгон зарласантай холбогдуулан “Хүүхдэд ээлтэй орон нутаг” санаачилгыг хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулсан сургалтад хэлтсийн дарга Ц.Тэгшжаргал
- Аймгийн прокурорын газраас зохион байгуулсан “Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны нэгдсэн зөвлөгөөнд” хяналтын улсын байцаагч Ө.Сонинбаяр
- Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудын төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн”-д хэлтсийн 13 албан хаагч
- Аймгийн Онцгой байдлын хэлтсээс “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах”, “Аюултай болон хортой бодисын олон улсын стандарт, тэмдэглэгээ уншиж ойлгох”, “Ахуйн хэрэглээний химийн бодис материалын зохистой хэрэглээ” сэдвүүдээр ахлах н.Өнөржаргал сургалт зохион байгуулж хэлтсийн 13 албан хаагч
- Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад 13 албан хаагч
- Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” сургалтад хэлтсийн дарга Ц.Тэгшжаргал тус тус хамрагдсан.

15. Улсын бүртгэл хийхэд тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг хэлэлцэх, Хяналтын улсын байцаагч, ахлах бүртгэгч нар чиглэл өгөх, улсын бүртгэлийн зөрчлийн тоог бууруулах, шинэ мэдээ мэдээллээр сургалт хийх зорилгоор 2019 оны 11 дүгээр 29-ний өдөр “Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн албан хаагчдын нэгдсэн уулзалт зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, нийт 27 албан хаагч хамрагдлаа. Үүнд Хяналтын улсын байцаагч, Иргэний ахлах бүртгэгч голлон сумын бүртгэгч нарт заавар зөвлөгөө өгч, Эд хөрөнгийн эрхийн улсын ахлах бүртгэгч, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч нар анхан шатны мэдээлэл хүргэхээс гадна нятлан бодогч “Үнэт цаасны тайлан гаргахад анхаарах асуудал” сэдвээр мэдээлэл өгсөн.

Мөн “Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Дохионы хэл суръя”, аймгийн Төрийн архивын тасгийн дарга “Албан хэрэг хөтлөлтийн стандарт” болон “Хадгаламжийн нэгж бүрдүүлэн, архивт шилжүүлэх нь”, ГБХЗХГ-ын Гэр бүлийн мэргэжилтэн “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх нь” сэдвээр сонирхолтой илтгэл тавьж, сонирхсон асуултад мэдээлэл өгсөн. Зөвлөгөөнд нийт 9 илтгэл тавигдсанаас гадна “Иргэний улсын бүртгэл хөтлөхөд тулгарч буй бэрхшээл” сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж, Хяналтын улсын байцаагч, Иргэний улсын ахлах бүртгэгч нар нэгдсэн чиглэл өгсөн.





Иргэдэд зориулсан эрх зүйн сургалтын чиглэлээр:

1. “Эрх зүйн боловсролыг иргэн бүрт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Айраг, Даланжаргалан, Иххэт, Дэлгэрэх, Алтанширээ Сайхандулаан, Мандах, Хатанбулаг, Замын-Үүд, Хөвсгөл сумдад Улсын бүртгэлийн багц хуулийн шинэчлэлийн талаарх мэдээллийг хүргэж, бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь шуурхай хүргэж ажилласан ба нийт 405 иргэнд мэдээ мэдээлэл хүргэсэн.

2. Байгууллагын мэдээллийн цагийн хуваарийг хагас жилээр төлөвлөн хэрэгжүүлж 72 төрийн байгууллагын 2227 албан хаагчид тус хэлтсээс иргэнд үзүүлдэг үйлчилгээ, Улсын бүртгэлийн багц хуулийн шинэчилсэн найруулга болон Зөрчлийн тухай хуулийн талаар мэдээлэл хүргэсэн.

3. “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ” аяны хүрээнд Сайншанд сумын 7 багт нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж нийт 500 орчим иргэнд тус хэлтсээс иргэдэд үзүүлдэг үйлчилгээ, Улсын бүртгэлийн багц хуулийн шинэчилсэн найруулга болон Зөрчлийн тухай хуулийн талаар мэдээлэл хүргэсэн.

4. Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Хууль сахиулах чиг үүргийн байгууллагуудын төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн”-д оролцож “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ” сэдвийн хүрээнд бүртгэлийн үйлчилгээг иргэдэд хамгийн хялбараар шуурхай хүргэх, тус хэлтсээс санаачлан хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар танилцуулж, цаашид төрийн байгууллагууд иргэний мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх талаарх хэлэлцүүлэг хийсэн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Улсын бүртгэлийн хэлтсийн алба хаагчдын эрхэлж байгаа ажил үүргийн онцлогтой холбогдон өртөж болзошгүй гэмт хэрэг, зөрчил, түүний үр дагаврын талаар мэдээлэл,

сэрэмжлүүлэг өгөх зорилгоор 03 дугаар сарын 29-ний өдөр Дорноговь аймгийн Цагдаагийн газрын эрүүгийн цагдаагийн тасгийн эдийн засгийн ахлах мөрдөгч хошууч Ц.Эхбаатарыг урьж “Эдийн засгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр сургалт зохион байгуулж мэдээллийн аюулгүй байдал, албан тушаалтны хариуцлага, албан хаагчийн аюулгүй байдал сэдвээр нээлттэй хэлэлцүүлэг хийж 15 албан хаагчийг сургалтад хамруулав.

УБЕГ-аас зохион байгуулсан “Мансууруулах бодист донтохын эсрэг” сургалтад хэлтсийн албан хаагчид бүрэн хамрагдсан.




Аймгийн ГХУСАСЗ-ийн 3186,1 мянган төгрөгийн санхүүжилтээр хэлтсийн байранд 8 камер, хяналтын дэлгэц байрлуулж, камержуулалтыг 100 хувь шийдвэрлэсэн.



Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:


Хэлтсийн авлигын эсрэг үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөөг хэрэгжүүлсэн. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, албан хаагчдыг авлигаас ангид байх тухай мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор Дорноговь аймаг дахь Авлигаас урьдчилан сэргийлэх иргэний хяналтын зөвлөлийн гишүүн Э.Оюунбилэгийн сургалтад хэлтсийн албан хаагчид хамрагдсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан төрийн албан хаагчдын



нэгдсэн зөвлөгөөнд “Авлигаас ангид сайн засаглалыг бэхжүүлэхэд төрийн албан хаагчдын үүрэг, оролцоо” сэдэвт сургалтад хэлтсийн албан хаагч нарыг хамруулсан.

“Бид авлига авахгүй, бид авлигыг дэмжихгүй” гэсэн зурагт хуудсыг мэдээллийн самбарт, үйлчилгээний танхимын цонх бүрд байрлуулсан.



Авлигын эсрэг албанд нийтийн болон ашиг сонирхлын зөрчлөөс дугаар зүйлд заасны захиргааны албан хугацаанд гаргуулсан.

Тайлант хугацаанд үйл ажиллагаатай ирүүлсэн авлига, гэмт ирээгүй байна



хуулийн 10 дугаар зүйл, Нийтийн хувийн ашиг сонирхлыг зохицуулах, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дагуу өөрийн хэлтсийн төрийн хаагчдаас ХАСХОМ-ийг хуулийн

байгууллагын болон албан хаагчдын холбоотой иргэн байгууллагаас хэргийн шинжтэй санал, гомдол

Бусад ажлын хүрээнд:

1.Тус хэлтсээс өндөр насны тэтгэвэрт гарсан 4 ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг Ахмадын өдрөөр зохион байгуулж, эмнэлгийн анхан шатны шинжилгээ, оношилгоонд албан хаагчдын хамт хамруулсан.

2. Дорноговь аймгийн Засаг дарга 2019 оныг "ГЭР БҮЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛ" болгон зарласантай холбогдуулан УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС нь 2019 оны 03 дугаар сарын 16-ны өдөр албан хаагчдыг гэр бүлийн хамт "Цэвэр агаар-Жаргалтай гэр бүл" эрүүл мэндийг дэмжсэн спортын арга хэмжээг зохион байгуулсан.




“Цэвэр агаар жаргалтай гэр бүл” спортын арга хэмжээ/

3. Сайншанд сумын 3 дугаар Багийн засаг дарга “Хотын соёл биднээс эхэлнэ” уриатай бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулан байгууллагын эзэмшлийн хуваарьт талбай болон байгууллагын гаднах хог хаягдлыг сар бүрийн 25-нд цэвэрлэж хэвшсэн.



4. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 3 дугаар сарын 21-ний өдрийн Пүрэв гарагийн 16 цагт Гамшгийн аюулын тухай “Зарлан мэдээллийн дадлага сургалтыг зохион байгуулсан.

Нэгдүгээр дохиогоор: Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагч нарыг болон Иргэний улсын бүртгэлийн тасагт үйлчлүүлж байсан иргэн У.Наранцэцэг ширээн доогуур оруулж аюулгүй байдлыг хангасан.



Хоёрдугаар дохиогоор: Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагч болон Иргэний улсын бүртгэлийн тасагт үйлчлүүлж байсан иргэдийг аюулгүйн гарц хаалгаар гаргасан.

Гуравдугаар дохиогоор: Иргэдийг аюулгүй талбай дээр гарган бүртгэлжүүлэн Онцгой байдлын газрын ажилтан Т.Чинзоригт мэдээлсэн.



5. Гэр бүлийн хөгжил, боловсрол, тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхдэд ээлтэй гэр бүлийн орчныг бий болгох, зорилго бүхий шинээр гэр бүл болж буй гэр бүлүүд, төрсний гэрчилгээ гардан авч буй бяцхан үрсдээ зориулж гэрлэлтийн болон төрсний гэрчилгээг ёслол хүндэтгэлтэйгээр гардуулах үйл ажиллагааг 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн зохион байгуулж хэвшээд байна. Тайлант хугацаанд нийт 6 удаагийн арга хэмжээг зохион байгуулж төрсний гэрчилгээ 98, гэрлэлтийн гэрчилгээг 53 иргэнд ёслол хүндэтгэлтэйгээр гардуулан өгсөн.



/Төрсний гэрчилгээ болон гэрлэлтийн гэрчилгээ гардуулах хүндэтгэлийн арга хэмжээний үеэр/

6. Мөн үйлчилгээний танхимд гэрлэлтийн болон төрсний гэрчилгээг ёслол хүндэтгэлтэйгээр гардуулах, дурсгалын зураг авахуулах фоныг хийж байрлуулсан.



/Дурсгалын зураг татуулах фон/

7. Аймгийн нэгдсэн эмнэлгээс зохион байгуулсан “Дусал цус амь аварна” цус цуглуулах аянд хэлтсийн алба хаагч нар хамрагдсан ба 5 албан хаагч цусны донор болж сар бүр цусаа бэлэглэж байна. Хүмүүнлэгийн үйлсэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж 4-н албан хаагчийг “Улаан загалмай нийгэмлэг”-ийн 80-н жилийн ойн хүндэт медалиар шагнасан.



8. Аймгийн Улаан загалмайн нийгэмлэгт хэлтсийн 13 албан хаагч жилийн татварыг төлж гишүүнээр элссэн. Мөн хамтын ажиллагааны хүрээнд Улаан загалмайн нийгэмлэгийн 80 жилийн ойг тохиолдуулан аялуулж байгаа туг, хандивын хайрцгийг үйлчилгээний танхимд 7 хоног байрлуулж нийт 84000 төгрөгийн хандив цуглуулж өгсөн.



9. Галын аюулгүй байдлыг хангах зорилгоор гал унтраах анхан шатны хэрэгслүүдийг зориулалтын дагуу байршуулсан.

10. аймагт зохион байгуулагдсан “Говийн чоно-2019” гамшгаас хамгаалах олон улсын иж бүрэн дадлага, сургуулилтын үйл ажиллагаанд хэлтсийн албан хаагчид оролцсон.




11. Мэдээллийн технологийн ажилтан Г.Ялалтын төрсөн дүүгийн эмчилгээний зардалд хандив өгөх зорилгоор Замын-Үүд сумын ЗДТГ, чөлөөт уран бүтээлчидтэй хамтран "SAVEZAYA" сайн үйлсийн аяныг тус суманд зохион байгуулж, хандивын хайрцаг аялуулсан, 1 200 000 төгрөгийн хандив цуглуулж өгсөн.



12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг бүрэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор хэлтсийн 20 улсын бүртгэгчид дохионы хэлний хичээлийн сургалтыг Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга Б.Баттуяа зохион байгуулсан.



13. 2019 оны 11 дүгээр сарын 15-ны "Оюутны эрхийн өдөр"-өөр аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн өдөрлөгт нэг өртөө болон оролцож, 100 гаруй багш, оюутнуудад улсын бүртгэлийн үйлчилгээний талаар мэдээлэл хүргэсэн. Үүнээс гадна оюутнуудын дунд "Би иргэний үнэмлэхээ авлаа" нэртэй Иргэний улсын бүртгэлийн хууль тогтоомжийн мэдээлэл агуулсан танин мэдэхүйн АХА тэмцээнийг 50 оюутныг хамруулан зохион байгуулсан. Тэмцээнд 1, 2, 3-р байр эзэлсэн оюутнуудыг 45.000 төгрөг бүхий Төрийн банкны хадгаламжийн дэвтрээр шагнасан.





14. Аймгийн Хууль эрх зүйн хэлтсийн харьяа байгууллагуудын дунд “Улсын бүртгэлийг хэн сайн мэдэх вэ?” 3 төрөл т тэмцээнийг зохион байгуулж, аймгийн Шүүхийн тамгын газар, Шүүхийн шинжилгээний алба, Төрийн архивын тасаг, Тагнуулын хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар мөн Долоодын говийн усны сав газрын захиргааны хамт олон нийт 20 албан хаагчийг хамруулан, улсын бүртгэлийн талаар Улсын бүртгэлийн багц хуулийн шинэчилсэн найруулга, холбогдох журмын хүрээнд асуултыг бэлтгэн танин мэдэхүйн АХА тэмцээнийг зохион байгуулж, мэдээлэл хүргэсэн.



16. Дорноговь аймгийн Хатанбулаг сум дахь хилийн 0168 дугаар ангийн Сулинхээрийн заставын хамт олонд 22 ширхэг ажлын хөвөнтэй бээлий, мөн Улсын бүртгэлийн мэдээлэл бүхий гарын авлагыг хүргүүлсэн.




17. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бүртгэлийн үйлчилгээний талаар мэдээлэл зөвлөгөө өгөх зорилгоор “Эх үрсийн хорвоогийн бүүвэй” ТББ-тай хамтран 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр “Хамтдаа” өдөрлөгийг зохион байгуулж, нийт 60 гаруй иргэнийг хамруулсан. Арга хэмжээний үеэр хүрэлцэн ирсэн иргэдийг халуун аньс, аарц, чацарганаар угтан, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, ГБХЗХГ-ын мэргэжилтэн “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх нь” сэдвүүдээр мэдээлэл

өгч, “Загийн говь” хоршоо, “Өрнөх хүч” ХХК-тай хамтран хүнс, шинэ хувцас, ахуйн бараа бүтээгдэхүүнийг цуглуулан “Өгөх өдөр”-ийн хүрээнд ирсэн иргэн бүрд өгсөн.



18. “Хайрхан уулаа хайрлан хамгаалъя” ажлыг төлөвлөн зохион байгуулж, 14 сумын улсын бүртгэгч аймгийн шүтээн уул Ханбаянзүрх хайрхан уулын орчим газрыг цэвэрлэж, ууланд очсон иргэдэд гарын авлага тараасан.



Хүний нөөцийн ажлын хүрээнд:

Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай А/131 дүгээр тушаал гарсантай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн Б/07 дугаар тушаалаар “Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах тухай “ тушаалаар орон тооны дээд хязгаарыг тогтоосон.

Тус хэлтэс нь 29 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Тус байгууллагад ажиллаж байгаа 28 төрийн албан хаагчаас эрэгтэй-4, эмэгтэй 24 албан хаагч ажиллаж, хүйсийн харьцаа 13:87 хувьтай байна.

Хэлтсийн ахлах нягтлан бодогч-1, төрийн захиргааны 23 албан хаагчийн ХАСХОМ-ын мэдүүлгийг цаасаар болон цахимаар авч баталгааны маягыг хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Тайлант хугацаанд шинээр томилогдсон 2 албан хаагчийн нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч УБЕГ-ын Захиргаа, хүний нөөцийн хэлтэст хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

Авлигын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд энэ онд 4 албан хаагч хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргаж, Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлсэн.

Сул орон тооны зарыг <http://burtgel.do.gov.mn> сайтад байрлуулж, иргэдээс ажилд орох хүсэлт, анкетыг хүлээн авсан. Ирүүлсэн анкетуудаас эхний шатны сонгон шалгаруулалтыг хийж шаардлага хангасан иргэний материалыг УБЕГ-т хүргүүлсэн.

Ажлын цаг ашиглалт, сахилга, дэг журам сахиулахтай холбоотойгоор хэлтсийн даргын 2019 оны "Үүрэг, чиглэл өгөх тухай" албан бичгийг хэлтсийн нийт алба хаагч нарт хүргүүлсэн.

Хурууны хээгээр цагийн бүртгэл хийх төхөөрөмжийг суурилуулж, 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн алба хаагч нар 08.00, 17.00 цагт хурууны хээгээр тогтмол цагаа бүртгүүлж хэвшсэн.

Мэдээллийн технологи, програм хангамж, тоног төхөөрөмжийн ажлын хүрээнд:

Мэдээллийн сангийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдалд хяналт тавьж ажиллаж байна. Үүнд: Хэлтсийн ажилчдын компьютерийн үйлдлийн системийн нууц үг болон програмд нэвтрэх нууц үгийг сард нэг удаа сольж баталгаат гарын үсэг зуруулж хэвшсэн.

"Сатилайт Повер ХХК болон Азийн хөгжлийн банкны ТА9372-МОН "Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох" төслийн хооронд 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан G003 дугаар бүхий "АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ"-ний дагуу Замын-Үүд суманд 01 дүгээр сарын 24-ний өдөр шилэн кабелийг суурилуулсан. Үүний дагуу шилэн кабелийг хүлээлцсэн актыг УБЕГ-ын Мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн.

Азийн хөгжлийн банкны төслийн зохицуулагч Г.Пүрэвсүрэн, Мэдээлэл технологийн зөвлөх Н.Батцэрэн нар 3-р сарын 21-ний өдөр Замын-Үүд сумыг онлайн сүлжээнд бүрэн холбож ашиглалтанд оруулсан.

Мөн авто зам дагуу байрлах Айраг, Даланжаргалан, Өргөн, Эрдэнэ сумыг онлайн сүлжээнд холбохоор интернэтийн судалгааг сумын Засаг дарга нарт хүргүүлсэн.

Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн ажлын хүрээнд:

Тайлант хугацаанд 1100 албан бичиг явуулж, 834 ирсэн бичгийг хүлээн авч, стандартын дагуу бүртгэж, даргын цохолтоор холбогдох албан хаагчдад шилжүүлж, хянан шийдвэрлүүлсэн. Албан хэрэг хөтлөлтийг ABLE програмд бүртгэж холбогдох албан байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан.

Тайлант хугацаанд иргэдээс нийт 38 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирсэн. Үүнээс:

- ✓ Иргэний бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар-2,
- ✓ Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар-1,
- ✓ Хуулийн этгээдийн бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар-1
- ✓ Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой / тэмдэгтийн хураамжийн буцаалт, гэх мэт/асуудлаар -7,
- ✓ Засгийн газрын 11-11 төвд гомдол-1
- ✓ Бусад 26 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.

ТАЙЛАН ХЯНАСАН:

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ТЭГШЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН

Э.АРИУНЦЭЦЭГ

